



ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2024 оны 05 дугаар сарын 06



№







1. Тендерийн нэр: Гэр хорооллын дундах гэрэлтүүлэг, цахилгаан хангамж, засвар шинэчлэлтийн сэлбэг материал худалдан авах, Увс, Өлгий сум
2. Барааны нэр: Гэр хорооллын дундах гэрэлтүүлгийн тоног төхөөрөмж

№		
1.	Үндэслэл	Эрчим хүчний сайдын 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/49 дүгээр тушаалын хавсралт
2.	Байршил, эдэлбэр газрын хэмжээ	Увс аймгийн Өлгий сумын төв, гэр хорооллын гудамжнуудад;
3.	Зориулалт, хүчин чадал	Гэр хорооллын гудамжны гэрэлтүүлэг (толгой) - 250 ширхэг. Шонтой гэрэлтүүлэг - 14 ширхэг
4.	Одоогийн байдал	Гэрэлтүүлэг хийгдээгүй гудамж, харагдах байдал хязгаарлагдмал;
5.	Захиалагч	Увс аймгийн Засаг даргын Тамгын газар
6.	Ажил гүйцэтгэх хугацаа	Захиалагч, нийлүүлэгч талуудын хооронд байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэслэл болгоно;
7.	Төсөл байгууллага: гүйцэтгэх	Бараа нийлүүлэх хуулийн этгээд;
8.	Шаардагдах хөрөнгийн хэмжээ:	Эрчим хүчний сайдын багцын хөрөнгөөр санхүүжигдэх 150,000,000 (нэг зуун тавин сая) төгрөг;
9.	Ажлын үе шат:	Техникийн тодорхойлолтын дагуу бараа татан авч, суурилуулах
10.	Иж бүрдэл:	Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 278 дугаар тогтоолын хавсралтад заасан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-д заасны дагуу бичиг баримтыг 4 хувь үйлдэж бүрдүүлж өгнө;
11.	Ажил гүйцэтгэхэд ашиглах хууль, норм, дүрэм, стандарт	<u>Монгол улсын хуулиуд:</u> - Барилгын тухай хууль - Эрчим хүчний тухай хууль

		<ul style="list-style-type: none"> - Бусад холбогдох хууль тогтоомж <u>Холбогдох стандарт, норм дүрэм</u> - Хот тосгон ба суурин газрын гудамж, зам талбайн гэрэлтүүлгийг төлөвлөх БД 30-102-11; - Монгол улсын цахилгаан тоног төхөөрөмжийн байгууламжийн дүрэм БД 43-101-03; - Байгалийн ба зохиомол гэрэлтүүлэг БНБД 23-02-08; - Гэрэлтүүлгийн ган шон техникийн шаардлага MNS2568:1983; - Гэрэлтүүлэг чимэглэлийн ажлын хөдөлмөр зарцуулалтын жишиг БНБД - 83-27-00; - Монгол улсын Сангийн сайдын 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 66 дугаар тушаал;
12.	Нэмэлт нөхцөл:	<ul style="list-style-type: none"> - Бараа нийлүүлэх компани нь гэрэлтүүлгийг суурилуулж хүлээлгэн өгөх; - Шонтой гэрэлтүүлгийг бетон сууринд суурилуулах; - Суурилуулах ажил эхлэхээс өмнө инженерийн байгууллага болон холбогдох бусад аж ахуйн нэгж болон байгууллагатай зөвшилцөх; - Гэрэлтүүлгийг суурилуулах явцад сумын ЗДТГ-аар хянуулж, холбогдох акт үйлдэх, - Нийлүүлж, суурилуулах тоног төхөөрөмж нь урьд өмнө нь ашиглагдаж байгаагүй, гарал үүслийн гэрчилгээ буюу сертификаттай, Монгол улс болон олон улсын чанар стандартын шаардлагыг бүрэн хангасан, шинэ байх; - Ажил гүйцэтгэх явцад талбайд ажиллаж буй ажилчдад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол өгч, машин механизмын аюулгүй ажиллагааны дүрмийг баримтлан ажиллах; - Ажлын явцад гарсан хог хаягдлыг сумын хог хаягдлын нэгдсэн цэгт хаях;

НИЙЛҮҮЛЭХ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, СЭЛБЭГ МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

№	Барааны нэр	Хүчин чадал	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Тайлбар
1.	Нарны самбартай Лед гэрэлтүүлэгч, цагаан тусгалтай, нарны эрчим хүчээр ажилладаг, хөдөлгөөн мэдрэгчтэй.	350Вт	ш	250	
2.	Нэг гэрэлтүүлэгчтэй шон, толгойн хамт, нарны эрчим хүчээр ажилладаг 350Вт	8м	ш	14	
3.	Кронштейн Ф160 /гэрэлтүүлэгчийг шонд бэхлэх/		ш	250	
4.	Лед гэрэлтүүлэгчийг кронштейнд холбох гар		ш	250	

5.	Дэд станц S11	250кВа	Ш	1	
6.	Дэд станцын 0,4кВ-ын ерөнхий шит IP-54 стандартын шаардлага хангасан байна. 2 хаалгатай байх	120*140*80 хэмжээтэй шит	Ш	2	
7.	Ерөнхий рубильник	РПС-6П 630А	Ш	2	
8.	Гүйдлийн трансформатор	ТТИ600/5А	Ш	6	
9.	Ухаалаг тоолуур	(MEASUREMENT DTZY88-G), (ENDLESS DTZD545S)	Ш	2	
10.	Гаргалгааны автомат, 160А	ВА88 /дүйцэхүйц/	Ш	4	
11.	Гаргалгааны автомат, 250А	ВА88 /дүйцэхүйц/	Ш	4	

3. Нарны зайн ЛЕД гэрлийн техникийн үзүүлэлт

Сайн чанарын тусгал сайтай IP 65 олон улсын стандартад нийцсэн, байгаль орчинд ээлтэй, өнгө үзэмжтэй, эдэлгээ урттай гэрэлтүүлэгч байх шаардлагатай.

1. Зориулалт: Гудамж, цэцэрлэг, авто зам
2. Чанарын үзүүлэлт: IP 65
3. Асаж унтрах байдал: Нарны эрчим хүчээр ажилладаг, харанхуй үед хөдөлгөөн мэдэрч гэрэлтэлт нэмэгддэг байх.
4. Гэрлийн хүчин чадал: 350Вт
5. Батарей: Lifepo4 төрлийн
6. Толь: Моно
7. Ажиллах хугацаа: 50000 цагаас багагүй.
8. Хөдөлгөөн мэдрэгчтэй.
9. Материал: PVC бат бөх, чанарын шаардлага хангасан.
10. Байгаль цаг уурын нөлөөлөл ус, тоос шороо нэвтрэхгүй, битүүмжилсэн байх
11. Ажлын температур: -30°C - $+35^{\circ}\text{C}$
12. Суурилуулах газар: Одоо байгаа цахилгаан дамжуулах агаарын шугамын төмөр бетон тулгуур
13. Гарал үүслийн гэрчилгээ, сертификаттай.
14. Галд тэсвэртэй, байгаль орчинд ээлтэй байх
15. Гэрлийн өнгө: Цагаан

4. Гэрэлтүүлгийн шон

Сайн чанарын тусгал сайтай IP 65 олон улсын стандартад нийцсэн, байгаль орчинд ээлтэй, өнгө үзэмжтэй, эдэлгээ урттай гэрэлтүүлэгч байх шаардлагатай.

1. Дээд хэсэг $\Phi 89 \times 4$ мм, суурийн хэсэг $\Phi 125 \times 5$ мм хэмжээтэй,
2. Ажиллах цаг уурын нөхцөл: -40°C - $+50^{\circ}\text{C}$
3. Суурилуулах газар: Өлгий сумын төв
4. Гэрэлтүүлгийн шон: MNS2568:1983-ийн шаардлага хангасан гэрэлтүүлгийн ган багана.
5. Гэрэлтүүлгийн шонгийн төмөр бетон суурь: $450:450 \times 600:600 \times 1200$ мм
6. Гэрэлтүүлгийн шонгийн ашиглалт: 20 жилээс багагүй.
7. Байгаль цаг уурын нөлөөлөл, зэврэлтээс хамгаалагдсан байх.
8. Бүх материал нь гарал үүслийн гэрчилгээ, сертификаттай.
9. Галд тэсвэртэй байх.

5. Цахилгаан тоноглол

1. IP 65 олон улсын стандартад нийцсэн, чанар, стандартын шаардлага хангасан байна.
2. Гарал үүслийн гэрчилгээ, сертификаттай, 1 жилийн баталгаатай,
3. Өмнө нь ашиглагдаж байгаагүй, шинэ.

6. Захиалагчийн хяналт: Өлгий сумын ЗДТГ, Увс ЦТС ХХК

1. Бараа материалын чанар, тоо хэмжээ, стандарт маркын дагуу хугацаандаа нийлүүлэгдэж, суурилуулагдаж байгаа эсэх;
2. Суурилагдаж буй бараа материал нь гарал үүслийн гэрчилгээтэй эсэх зэрэгт хяналт тавина.

7. Нийлүүлэгч байгууллага

1. Нийлүүлэгч нь тоо хэмжээний дагуу чанартай, орчин үеийн загвар дизайнтай бараа материалыг гэрээний хугацаанд багтаан нийлүүлж, суурилуулна.
2. Гэрэлтүүлгийн шонг БМ-200 маркын 450:450x600:600x1100мм-н харьцаатай төмөр бетон суурь угсарч, угсарсан суурь дээр суурилуулна.
3. Гэрэлтүүлгийн толгойг одоо байгаа цахилгаан дамжуулах агаарын шугамын төмөр бетон тулгуур дээр суурилуулна.
4. Тендерт шалгарсан нийлүүлэгч нь импортын бараа материал ашиглах нөхцөлд гарал үүсэл, тохирлын гэрчилгээ, сертификат, лабораторын шинжилгээний дүнг хавсаргасан байх. Үндэсний үйлдвэрийн материалыг ашиглах нөхцөлд "Бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ" лабораторын шинжилгээний дүнг хавсаргаж ирүүлнэ.
5. Увс аймгийн Өлгий сумын төв хүртэлх бараа материалын тээвэрлэлтийн зардлыг нийлүүлэгч хариуцана.
6. Бараа, материалын тээвэрлэлтийн явцад гарч болзошгүй гэмтэл, элэгдэл хорогдлын зардлыг нийлүүлэгч байгууллага өөрөө хариуцана.
7. Үйлдвэрлэгчийн гаргасан баталгаа худалдан авагчид байх ёстой. Баталгаат хугацаа хүлээн авсан өдрөөс эхлэн 1 жил байна. Үйлдвэрлэгчээс олгосон урт хугацааны баталгааны хугацаа нь худалдан авагчид өөрчлөлтгүйгээр олгогдох ёстой.
8. Бүрэн ажиллагааг хангахын тулд нийлүүлэгдэх бараа материалд зайлшгүй шаардлагатай бүх нэмэлт тоноглол ба бүрэлдэхүүн хэсгүүд дагалдаж байх ёстой.
9. Угсралт суурилуулалтыг хийж ажиллагааны 72 цагийн туршилт хийж актаар баталгаажуулан хүлээлцэнэ.

Дээрхи техникийн тодорхойлолтод заасан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагч барааг буцаах, хүлээн авахгүй байх арга хэмжээ авах эрхтэй.

ХЯНАСАН:

ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

 Б.БАТТОГТОХ

ЗӨВШӨӨРСӨН:

ӨЛГИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГА

М.



Ж.ОЧИРБАТ

БОЛОВСРУУЛСАН:

ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Б.

Б.БОЛОР

ӨЛГИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ

A handwritten signature in black ink, likely belonging to Z. Molomjamc.

З.МОЛОМЖАМЦ